

2024 оны 04 сарын 26 өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан
дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.9 дэх заалт, 2024 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

2024 оны 04 сарын 26 өдөр

№ 02

Улаанбаатар хот

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.14 дэх заалт, 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хавсралтаар баталсугай.
2. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөнд тодотгол оруулж, шийдвэрийг олон нийтэд зохих журмын дагуу мэдээлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Тогтохбаяр)-д даалгасугай.
3. Батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд хүрэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Тогтохбаяр)-д тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

**"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН 2024 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ САНАЛ**

/мянган төгрөг/

№	Үзүүлэлтүүд	2022 оны гүйцэтгэл*	2023 он		2024 оны төлөвлөгөө	2023 оны гүйцэтгэлтэй харьцуулсан өөрчлөлт	
			Тодотгосон төлөвлөгөө	Хүлээгдэж буй гүйцэтгэл*		%	мөнгөн дүн
1	Нийт орлого:	4,268,416	9,783,712	13,777,494	17,778,554	29%	4,001,060
1.1	Үнэт цаасны арилжааны шимтгэл	2,031,112	4,112,424	2,583,028	3,147,318	22%	564,290
1.2	УУББ-ийн арилжааны шимтгэл		2,552,931	4,821,917	6,521,185	35%	1,699,268
1.3	Жилийн хураамж, үйлчилгээний хөлс	1,869,696	2,365,350	2,317,088	1,485,794	-36%	-831,294
	MIT ашиглалтын орлого	6,364					
1.4	Хүүгийн орлого		397,500	3,782,215	6,250,000	65%	2,467,785
1.5	Бусад	361,244	355,507	273,246	374,257	37%	101,011
2	Нийт зардал:	3,629,535	6,698,000	7,395,090	9,428,972	28%	2,033,882
2.1	Үйл ажиллагааны зардал	2,011,822	3,997,527	5,022,743	6,226,234	24%	1,203,491
2.2	Удирдлагын зардал				449,188	-	
2.3	ҮХ элэгдлийн зардал	396,509	928,994	600,868	900,532	50%	299,664
2.4	Арилжааны систем ашиглалтын зардал	1,221,204	1,771,479	1,771,479	1,853,017	5%	81,538
3	Татварын өмнөх цэвэр орлого /алдагдал/	769,748	3,085,712	6,382,404	8,349,582	31%	1,967,178
4	Орлогын татвар	123,520	391,086	316,104	834,958	164%	518,854
5	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/	646,228	2,694,626	6,066,300	7,514,624	23.9%	1,448,323.8
6	Нийт авлага /цэвэр/	504,659	51,460	674,334	250,092		(424,242)
7	Нийт өглөг /системийн зардал оруулж тооцооноор/	1,989,503	218,319	1,031,617	848,455		(183,162)
	УУББ-ийн арилжааны дэнчингийн мөнгө			881,747,146	881,747,146		-
8	Ажиллагсдын тоо	53	72	72	72		-
9	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох үйл ажиллагааны зардал	0.85	0.68	0.54	0.53		(0.01)
10	Хөрөнгө оруулалт	557,807	5,899,400	1,093,971	1,110,664	1.5%	16,693

2024 оны 04 сарын 26 өдөр

№ 03

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.15 дахь заалтууд, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 8 дугаар тогтоолд дараах өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:
 - 1) 1, 7 дахь хэсгүүд болон 4 дэх хэсгийн 1-т заасныг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
 - 2) 4 дэх хэсгийн “1.10 дахь заалт” гэснийг хассугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 8 дугаар тогтоолд өөрчлөлт оруулснаас бусад хэсгийг хүчин төгөлдөр хэвээр үлдээсүгэй.
3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР